



## ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Чанар, аюулгүй байдал, эрсдэл, халдварын сэргийлэлт,  
хяналтын багийн гишүүн томилох тухай

Монгол Улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 116/A/565 дугаар тушаалын 2.3, 3.19 дэх заалт, A/566 дугаар тушаал, 2019 оны 11 сарын 29-ны өдрийн A/536 дугаар тушаалын 1.5.4, 5 дугаар заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн A/322 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн “Чанар, аюулгүй байдал, эрсдэл, халдварын сэргийлэлт хяналтын багийн орон тооны бус гишүүдийн ажиллах журам”-г нэгдүгээр, “Чанар, эрсдэл, халдварын сэргийлэлт хяналтын багийн орон тооны бус ахлагч”-г хоёрдугаар, “Чанар, эрсдэл, халдварын сэргийлэлт хяналтын багийн орон тооны бус гишүүд”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үйл ажиллагаанд холбогдох дүрмийг мөрдлөг болгон ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга (Б.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн A/143 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.





Гэмтэл согог судлалын үндэсний төвийн  
захирлын 2026 оны 01 дугаар сарын 14-ны  
өдрийн №07 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



## ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРСДЭЛ, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮДИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмаар Гэмтэл согог судлалын үндэсний төв (Цаашид ГССҮТ гэх)-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүлийн 15.1-д заасан Эрүүл мэндийн бүх байгууллагуудад “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба/баг (цаашид ЭМТҮЧАБ-ын алба гэх) ажиллана.

1.3.ЭМТҮЧАБ Алба нь Монгол Улсын Шадар Сайд, ЭМСайдын хамтарсан 2019 оны 116/A/565 тоот тушаалаар батласан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дүрэм”-ийг, ЭМСайдын 2019 оны A/566 тоот тушаал, ЭМСайдын 2019 оны A/536 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн байгууллага дахь халдварын сэргийлэлт, хяналтын эмч, сувилагийн ажлын чиг үүрэг”-ийг баримтлан ажиллана.

1.4.Уг гишүүд нь тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайржуулах, үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, эрсдэл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, зохицуулах үүрэгтэй.

1.5.Өөрийн тасаг албадад явагдаж буй үйл ажиллагааг сайжруулах, цаашлаад бодит үр дүнд хүрэхийн тулд үйл бүх төрлийн ажлыг тогтмол зохион байгуулах

1.6.Ажлыг жил бүрийн Чанар сайжруулах төлөвлөгөөнд тусган оруулсан байх

### ХОЁР. ЗОРИЛГО

2.1.Тасаг/алба дахь тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжин туслах, бодит үр дүнд хүрэх

### ГУРАВ.ТАСГИЙН ЭРХЛЭГЧ/АЛБАДЫН ДАРГА, ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ

3.1.Эмнэлзүй хариуцсан дэд захирал - Эмнэлгийн эмнэл зүйн үйл ажиллагаатай холбоотой талуудын уялдаа холбоог хангах, хамтран ажиллах үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Санхүүгийн бүртгэлийн албаны дарга – Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, урамшуулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэн зарцуулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.Сувилахуй хариуцсан дэд захирал – Сувилахуйн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.Тархвар/халдвар судлаач – Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар, үйлчлүүлэгч болон эмч мэргэжилтний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулна.

3.5.Эмнэл зүйн эм судлаач – Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, гаж нөлөөг судлах, тендерээр нийлүүлэгдэж буй эмийн чанар, жор бичилт, эмийн эмчилгээний чанар, аюулгүй байдалд мэргэжлийн дагуу хяналт тавьж ажиллана.

3.6.Статистик, тандалт судалгааны албаны дарга – Тусламж үйлчилгээний чанарын албаны үйл ажиллагаанд шаардлагатай тоон мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийхэд мэдээллээр ханган ажиллана.

3.7.Эмгэг судлаач эмч – Эмч мэргэжилтнийг эмнэл зүйн эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх, тохиолдол бүрийг бүртгэх, шалтгааныг тодруулах, шалтгаан хамаарлын шинжилгээ хийх багт орж ажиллах, эргэн мэдээллэх, суралцах үйл ажиллагааг чиглүүлэн ажиллана.

3.8.Эрүүл мэндийн даатгалын эмч – Даатгалын байгууллагатай хамтран ажиллах, даатгуулагчийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, учирч буй эрсдэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.9.Мэдээллийн технологич – Үйлчлүүлэгчийн аюугүй байдалтай холбоотой мэдээллийн технологийн арга хэрэгслийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, үйлчлүүлэгчийн нууцлалыг хадгалах, чанар аюулгүй байдлын мэдээллийн санг байгууллагын түвшинд үүсгэн хэвийн үйл ажиллагааг хангах хэрэглэгчийн нууцлалыг хангах, холбогдох эрхийн хязгаарлалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх

3.10.Аж ахуй, инженер техникийн алба болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер – Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх, шалгалт тохируулгад хамруулах, хэмжих хэрэгслийн баталгаажилтыг стандартын байгууллагатай хамтран гүйцэтгэх, тоног төхөөрөмжид хугацаат засвар үйлчилгээ үзүүлэх, тоног төхөөрөмжтэй холбоотой доголдол гарсан бол анхааруулах журмыг ЭМТҮЧАБАлбатай хамтран гаргаж хэрэгжилтийг хангах үүрэг гүйцэтгэнэ.

### **ДӨРӨВ.ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ**

4.1.ГССҮТ-ийн чанар, аюулгүй байдлын орон тооны бус гишүүд тусламж, үйлчилгээний чанар аюулгүйбайдлыг сайжруулахад дараах чиг үүргийг хэрэгжүүлэн оролцоно.

4.2.Чанар аюулгүй байдлын орон тооны бус гишүүд, баг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны үндсэн ажилчдын үйл ажиллагааг дэмжин оролцоно.

4.3.Чанар аюулгүй байдлын орон тооны бус гишүүд нь тасаг, албадын үйл ажиллагаатай холбоотой тохиолдлоос урьдчилан сэргийлэн ажиллахын тулд тасаг албадын уялдаа холбоог дэмжин ажиллах

4.4.ЭМТҮЧАБАлбаны дарга, менежер, мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.

4.5.Тасаг/албадын тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдалд тогтмолд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж арга зүй дэмжлэг зөвлөгөө үзүүлнэ

4.6.Чанар сайжруулах чиглэлээр тасаг/албадийн ажилтнуудад сургалт орох

4.7.Тасаг/албадын тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллана.

4.8.Тасаг/албадад мөрдөж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж заавар мөрдүүлж үр дүнг тооцож ажиллана.

4.9.Хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах

4.10.Тасаг/албадад тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр мөрдөх дүрэм журам заавар хяналтын хуудас зэрэгт хяналт тавих

4.11.Тасаг/албадад тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хариу арга хэмжээ авах дахин гархаас сэргийлэн сайжруулах арга хэмжээ авч ажиллах

### **ТАВ.ЭРСДЭЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ**

5.1.Тасгийн эрсдэл хариуцсан гишүүн үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл, тохиолдол бүртгэх мэдээлэх журамд заасны дагуу хариу арга хэмжээг авах үйл ажиллагааг өөрийн тасаг дээр гардан хэрэгжүүлж, дахин давтагдахаас сэргийлэх, бууруулах арга хэмжээг авна.

5.2.Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бусад тохиолдож болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс мэдээлэл, туршлага хуваалцах үйл ажиллагааг ЭМТҮЧАБАлбатай хамтран хэрэгжүүлнэ.

5.3.Томилогдсон хариуцсан гишүүн нь тасгийн бусад ажилчидтай хамтран үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдалтай холбоотой гадаад, дотоод орчны эрсдэл, эмнэлзүйн эрсдэлийг тодорхойлон боловсруулан ажиллана.

5.4.Тасгийн өдөр тутмын үйл явц, дотоод болон гадаад орчны талаар эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг хянах, бууруулах зорилгоор тасгийн эрсдэлийн төлөвлөгөөнд шинэчлэл хийх санал, төслийг боловсруулан эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна.

5.5.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой аюул, эрсдэлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээг баримтжуулан дүн шинжилгээ хийж түгээн дэлгэрүүлнэ.

5.6.Тасгийн завсар үйлчилгээний өмнө, засварын явцад, засварын дараа гарч болох эрсдэл гэх мэт гадаад болон дотоод орчны эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан төлөвлөж шийдвэрлэж хэвших

5.7.Эрсдэлийг бүртгэх, үнэлэх, эрэмбэлэх хариу арга хэмжээ авах талаар тасгийн ажилтнуудад дотоод сургалт зохион байгуулах.

### **ЗУРГАА.ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ**

6.1.Тасгийн халдвараас сэргийлэлтийн үндсэн шалгууруудын мөрдөлтөнд хяналт тавих, мэдээлэл түгээх

6.2.Тасгийн хэмжээнд халдварын сэргийлэлт хяналт, эрүүл ахуйн чиглэлээр сургалтыг тасралтгүй зохион байгуулах, зөвлөмж, гарын авлага материалыг тасгийн нөөц боломжоор хангах (ГССҮТөвийн Халдварын сэргийлэлт хяналтын алба (Цаашид ХСХА гэнэ.) мэргэжил арга зүйгээр хангах)

6.3.Тасгийн хүрээнд халдварын сэргийлэлт хяналтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх

6.4.Тасагт гарч болох эрсдэлт хүчин зүйлийг тогтоох

6.5.Тасгийн бичил биетний эсрэг эмийн хэрэглээнд ГССҮТөвийн ХСХАлбатай хамтран дүн шинжилгээ хийх

6.6.Тасгийн хүрээнд Клиник эм зүйн албатай хамтран антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх

6.7.Тасгийн ажилчдад эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх талаар мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх

6.8.Тасгийн өртөлтөөс сэргийлэх арга хэмжээг ГССҮТөвийн ХСХАлбатай хамтран зохион байгуулж ажиллана.

6.9.Томилогдсон тасгийн эрүүл мэндийн ажилтны халдвараас сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажлыг ажлыг зохион байгуулж, дархлаажуулалтын талаар тасгийн хэмжээнд нэгдсэн бүртгэл үүсгэх

6.10.Тасгийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэгт хяналт хийх, бүртгэл үүсгэх

6.11.Тасгийн ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдээллийн нууцыг хадгална.

6.12.Тасагт үйлчлүүлж буй иргэд халдварт өртөх эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ГССҮТөвийн ХСХАлбанд хүргүүлэх

### **ДОЛОО.ТАСАГ/АЛБАДЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛ, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН БАГИЙН ГИШҮҮДИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

7.1.Тасаг нэгж дэхь тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах боломжуудыг тодорхойлж түүний дагуу сайжруулан бодит үр дүнд хүрч, ололтыг бататган хадгалах.

Өөрийн тасаг нэгж дээр явагдаж буй үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, цаашлаад бодит үр дүнд хүрэхийн тулд бүхий л төрлийн тоон мэдээллийг цуглуулах. Тоон мэдээллийг үндэслэн эмч, эмнэлгийн ажилчид, алба, тасаг нэгжийн түвшинд, эмнэлгийн түвшинд үйл ажиллагаа явуулах.

7.2.Чанар, аюулгүй байдал, эрсдэл, халдварын сэргийлэлт, хяналтын баг нь тасгийн эрхлэгч/даргын санал болгосноор томилон 3-аас багагүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

7.3.Чанар, аюулгүй байдлын багийн гишүүд эмнэлзүйн үйл ажиллагаанд түлхүү оролцох тасаг/нэгж байна. Үүнд:

7.3.1.Чанар, аюулгүй байдал, эрсдэл, халдварын сэргийлэлт, хяналтын багийн ахлагч Тасгийн эрхлэгч/Албадын дарга байх бөгөөд тасгийн эрхлэгч/албадын дарга томилсноор чанарын багийн гишүүд томилогдоно. Чанар, аюулгүй байдал, эрсдэл, халдварын сэргийлэлт, хяналтын багийн гишүүд нь ахлагчийн шууд удирдлагад хамаарагдаж ажиллана.

7.3.2.Чанар хариуцсан эмч/ажилтан,

7.3.3.Эрсдэл аюулгүй байдал хариуцсан эмч/ажилтан

7.3.4.Халдварын сэргийлэлт, хяналт хариуцсан эмч/ажилтан

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн  
захирлын 2026 оны 01 дугаар сарын 12-ны  
өдрийн 407 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**ЧАНАР, ЭРСДЭЛ, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН БАГИЙН  
ОРОН ТООНЫ БУС АХЛАГЧИД**

№	Тасаг, алба	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4
1	Захиргаа, удирдлага	Эмнэлзүй хариуцсан захирал	Л.Дагвадорж
2		Үйл ажиллагаа хариуцсан захирал	Б.Батзориг
3		Салбар эмнэлгийн эмнэлзүй хариуцсан захирал	О.Хишигсүрэн
4		Сувилахуй хариуцсан дэд захирал	Г.Дэлхийцэцэг
5	Санхүү бүртгэлийн алба	Санхүү бүртгэлийн албаны дарга	Ц.Энхбаяр
6	Нийгмийн эрүүл мэндийн алба	Албаны дарга	Д.Одгэрэл
7	Аж ахуй, инженер техникийн албаны дарга	Албаны дарга	Ц.Лхагвасүрэн
8	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга	Албаны дарга	Б.Батзаяа
9	Статистик, тандалт судалгааны албаны	Албаны дарга	Б.Түмэн-Өлзий
10	Эрүүл мэндийн даатгалын зохицуулалтын албаны дарга	Албаны дарга	Б.Мөнхдөл
11	Мэдээлэл технологийн албаны дарга	Албаны дарга	Э.Батдорж
12	Эрдэм шинжилгээ сургалтын алба	Албаны дарга	С.Баатаржав
13	Эдийн засаг, төлөвлөлт, маркетингийн алба	Албаны дарга	Э.Сайнбилэг

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн  
захирлын 2026 оны .07 дүгээр сарын 12-ны  
өдрийн №07... тоот тушаалын гуравдугаар хавсралт



**ТАСАГ/АЛБАДЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛ, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН БАГИЙН ГИШҮҮД**

№	Тасаг/алба	Багийн ахлагч	Чанар, аюулгүй байдал хариуцсан гишүүн	Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан гишүүн	Халдварын сэргийлэлт хяналт хариуцсан гишүүн
1	2	3	4	5	6
<b>ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ (ТӨВ ЭМНЭЛЭГ)</b>					
1	Сувилахуйн алба	О.Сувд-Эрдэнэ	Б.Цэдэнсодном	С.Баярцэцэг	М.Цэрэнпүрэв
		Албаны дарга	Арга зүйч	Арга зүйч	Арга зүйч
2	Амбулаторийн тасаг	М.Төгсбаяр	Ц.Мандухай	Ц.Мөнгөнцэцэг	Б.Бат-Оюун
		Тасгийн эрхлэгч	Зүрх судасны их эмч	Зүрх судасны их эмч	Сувилагч
3	Яаралтай тусламжийн тасаг	А.Сэргэлэнхад	Г.Сандаг Ц.Мөнх-Эрдэнэ З.Анхбаяр Э.Эрдэнэ	Х.Мөнхтөр Б.Даваабаяр	Г.Лхагвадорж Б.Баасантөгс
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
4	Эрчимт эмчилгээний тасаг	Ө.Бямбаринчин	Ж.Адъяасүрэн Ц.Цэцэгбал	Ж.Адъяасүрэн Я.Саранзэв	О.Гантогтох Б.Билгүүн Э.Мөнгөнзаяа Ц.Уранчимэг
		Тасгийн эрхлэгч	Ахлах сувилагч Сувилагч	Ахлах сувилагч Сувилагч	Их эмч Их эмч Сувилагч Сувилагч
5	Дүрс оношилгооны	Г.Лхагвасүрэн	Д.Сарангэрэл Д.Ундармаа	Ө.Лайла Б.Мөнхжин	Т.Балдорж Э.Гантөмөр
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
6	Сэргээн засах эмчилгээний тасаг	Ч.Юмчмаа	О.Мичидмаа О.Маргад	Э.Энэрэл Э.Оюунтуяа	Б.Баяржаргал Э.Сосорбарам
		Тасгийн эрхлэгч	Их эмч Хөдөлгөөн засалч	Их эмч Хөдөлгөөн засалч	Хөдөлгөөн засалч Хөдөлмөр засалч
7	Мэс засал, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг	Ж.Түмэн-өлзий	А.Бадмаараг	Б.Батцэцэг Э.Эрдэнэчимэг	Б.Гүн-Үйлс Б.Бямбацэцэг
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч Сувилагч
8	Лабораторийн нэгдсэн тасаг	Б.Очирсүрэн	Д.Гантуяа	Г.Төмөрбаатар Э.Бямбасүрэн	П.Бямбасүрэн
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч

1	2	3	4	5	6
9	Гар сарвууны мэс заслын тасаг	Л.Нанжид	Ж.Баярмагнай	Э.Ганчимэг	Б.Эрхэмбаяр
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
10	Насанд хүрэгсдийн мэс заслын тасаг	Б.Баатаржав	Т.Отгонболд А.Алтантуяа	Э.Баасансүрэн Б.Бат-Амгалан	О.Бямбаа
		Тасгийн эрхлэгч	Их эмч Ахлах сувилагч	Их эмч Сувилагч	Их эмч
11	Хүүхдийн мэс заслын тасаг	М.Болдбаатар	Б.Солонго Л.Жавзансүрэн Г.Анхцэцэг	Х.Ганзориг Э.Анужин Н.Халиунаа	О.Бат-Эрдэнэ Д.Одсүрэн М.Бат-Эрдэнэ
		Тасгийн эрхлэгч	Их эмч Сувилагч Сувилагч	Их эмч Сувилагч Сувилагч	Их эмч Сувилагч Сувилагч
12	Нурууны мэс заслын тасаг	Л.Бат-Эрдэнэ	Б.Тайванбат	Г.Отгонтөгс	М.Цэлмэг
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
13	Хавсарсан гэмтлийн мэс заслын тасаг	П.Баярсайхан	Э.Алтаншагай Н.Энхцэцэг	Ж.Мөнхдөл	Б.Батболд
		Тасгийн эрхлэгч	Их эмч Ахлах сувилагч	Их эмч	Их эмч
14	Толгойн мэс заслын тасаг	Ц.Баясгалан	Д.Дашням Н.Очиртуяа Л.Даваадулам	Л.Бум-Аюуш Ц.Эрдэнэ С.Мөнхжаргал	Б.Лхамсүрэн Э.Энхтүвшин Б.Наранчимэг
		Тасгийн эрхлэгч	Их эмч Их эмч Сувилагч	Их эмч Их эмч Сувилагч	Их эмч Их эмч Сувилагч
<b>ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ (САЛБАР ЭМНЭЛЭГ)</b>					
15	Түдэгдэлтийн төв	Нарантунгалаг	Х.Мөнхзул	Д.Жүгдэрнамжил	О.Энхсүлд
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
16	Спортын гэмтлийн төв	С.Батсүх	О.Амгаланхүү	Б.Түвшинбаяр	С.Золжаргал
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
17	Ясны эмгэгийн мэс заслын тасаг	Э.Ниндэвдэмбэрэл	Ч.Мөнхцэнгэл	Г.Батбямба	А.Амгаасэд
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
18	Нөхөн сэргээх мэс заслын тасаг	О.Цэрэндорж	Ц.Оюунболд	Э.Мөнхбат	Б.Пүрэвдорж
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
19	Сэргээн засах эмчилгээний тасаг	Ч.Юмчмаа	Э.Гэрэл	Э.Энхчимэг	Э.Энхболд
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
20	Эрчимт эмчилгээний тасаг	Ууганбаяр	М.Мөнхтуяа	Г.Баяр	Б.Насанбат
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Их эмч
21	Мэс засал мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг	Б.Мөнхбаяр	У.Бахберсин	Т.Нямсүрэн	Н.Цэвээндарь
		Тасгийн эрхлэгч	Их эмч	Их эмч	Сувилагч

1	2	3	4	5	6
22	Амбулаторий н тасаг	Б.Батаа	Ө.Зулцэцэг	Ц.Энхтуяа	Б.Гэрлээ
		Тасгийн эрхлэгч	Ахлах сувилагч	Бүртгэл мэдээллийн ажилтан	Сувилагч
<b>ДЭМЖИХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ</b>					
23	Хүний нөөцийн алба	А.Цэрэндолгор	Б.Мөнгөнцэцэг	Т.Номинтуяа	-
		Албаны дарга	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	-
24	Клиник эм зүйн алба	Б.Болор-Ундрах	Р.Мянганбаяр	Б.Сүрэнжав	З.Лхагва- Эрдэнэ
		Албаны дарга	Эм зүйч	Эм зүйч	Эм зүйч
25	Хоол эмчилгээний тасаг	Б.Бямбасүрэн	Х.Мөнгөнцэцэг	А.Анударь	Х.Алтанчимэг
		Албаны дарга	Тогооч	Хоол зүйч	Тогооч
26	Халдварын сэргийлэлт, хяналтын алба	Э.Баасансүрэн	Г.Оюун-Эрдэнэ Э.Рэнцэн-Очир	Т.Баасанжаргал А.Ариунцэцэг	-
		Албаны дарга	Халдвар судлаач	Халдвар судлаач	-
27	Эрдэм шинжилгээ сургалтын алба	С.Баатаржав	А.Урангоо	Э.Хажидмаа	Э.Болормаа
		Албаны дарга	Арга зүйч	Арга зүйч	Арга зүйч
28	Мэдээлэл технологийн алба	Э.Батдорж	М.Наранжаргал Б.Дэлгэрхангай	Э.Номинцэцэг Ч.Эрдэнэ	Э.Батдорж
		Албаны дарга	Инженер	Инженер	Албаны дарга
29	Нийгмийн эрүүл мэндийн алба	Д.Одгэрэл	Б.Золжаргал	Л.Энхтуяа	-
		Албаны дарга	Мэргэжилтэн	Мэргэжилтэн	-
30	Аж ахуй инженер техникийн алба	Ц.Лхагвасүрэн	С.Гансүх	Н.Бямбаа	Ш.Түвдэндорж
		Албаны дарга	Инженер	Инженер	Дулааны техникч
31	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба	Б.Батзаяа	Б.Нандин- Эрдэнэ	П.Даваадорж	
		Албаны дарга	Инженер	Инженер	
32	Статистик тандалт судалгааны алба	Б.Түмэн-Өлзий Б.Оюун	Г.Цэрэн Ч.Энхчимэг	Э.Анубүжин Б.Баянзул	Х.Мөнхзул
		Албаны дарга Бага эмч	Эпидемиологич Бага эмч	Эпидемиологич НЭМмэргэжилтэн	Эпидемиологич